



НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ХӨДӨӨ АЖ АХУЙ 2019

УЛААНБААТАР ХОТ
2020 ОН

ХЯНАСАН:

Д.Мөнхзул

ЧД-ын Статистикийн хэлтсийн дарга

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

Б.Энхжаргал

ЧД-ын Статистикийн хэлтийн мэргэжилтэн



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, САМБУУГИЙН ГУДАМЖ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ III БАЙР, 401 тоот

Утас: 70113013

70130767

70110767

11-310767

Цахим хуудас: www.ubstat.mn

www.chingeltei.gov.mn

И-мэйл: chingeltei@nso.mn



Монгол улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбар юм.

Хөдөө аж ахуйн нийт үйлдвэрлэлийн хэмжээг жилийн туршид мал, амьтдыг өсгөн үржүүлсний болон ургамал, тариа, хүнсний ногоо тарьж ургуулсны үр дүнд бий босон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний өртгийн нийлбэр дүнгээр тодорхойлно.

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад зориулагддаг.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТ



ГАЗАР ТАРИАЛАН



МАЛ АЖ АХУЙ



ТЭЖЭЭВЭР АМЬТАН



ГЭРИЙН ТЭЖЭЭМЭЛ НОХОЙ, МУУР





ГАЗАР ТАРИАЛАН:

Нийслэлийн нутаг дэвсгэрт тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс тариалсан талбай, ургац хураалтын мэдээг хороод авч дүүрэг, нийслэлийн статистикийн газар, хэлтэсээр дамжин Үндэсний статистикийн хороонд нэгтгэн боловсруулдаг бөгөөд нийслэлд гол төлөв төмс, хүнсний ногоо тариалж байна.

Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2019 онд 0.135 га талбайд төмс, 0.315 га талбайд хүнсний ногоо тариалсан бөгөөд 2.6 тн төмс, 5.7 тн хүнсний ногоо хураан авсан.

Хүснэгт 1. ТАРИАЛСАН ТАЛБАЙ, ХУРААСАН УРГАЦ, хороодоор, 2019 он

Хороо	Тариалсан талбай /га/		Хураасан ургац /тн/	
	Төмс	Хүнсний ногоо	Төмс	Хүнсний ногоо
8-р хороо	0	0.010	0	0.190
12-р хороо	0.014	0.059	0.196	0.381
15-р хороо	0	0.027	0	0.178
17-р хороо	0.014	0.095	0.892	2.731
19-р хороо	0.107	0.124	1.520	2.168
Нийт	0.135	0.315	2.608	5.648

Чингэлтэй дүүргийн 2019 оны нийт ургац хураалтын 32%-г төмс, 21%-г өргөст хэмх, 10%-г байцаа, 8% -г улаан лооль, 8%-г лууван, 6%-г сонгино, 4%-г улаан манжин, үлдсэн 11%-г бусад хүнсний ногоо эзэлж байна.

Зураг 1. УРГАЦ ХУРААЛТ, тонн, 2019 он





МАЛ АЖ АХУЙ:


Монгол улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн хэмээн томъёолж энэ ч утгаараа Статистикийн тухай Монгол Улсын хууль, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсүүд жил бүрийн 12-р сарын 7-17 өдрүүдэд “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-ыг зохион байгуулж үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж салбарын талаархи удирдлагын шийдвэр гаргалтанд мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.


Мал тооллогын зорилго нь мал, амьтдын өсөлт, бууралт, сүргийн бүтцэд гарч байгаа өөрчлөлтийг улсын хэмжээгээр болон бүс нутаг, засаг захиргааны нэгжийн хуваарийн дагуу мал амьтдыг төрөл тус бүрээр нарийвчлан гаргаж, тухайн нэг жилийн доторх мал сүргийн нөхөн үйлдвэрлэлийн үр дүнгийн холбогдох бүх мэдээллийг үнэн зөв тодорхойлоход оршино.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 119 дүгээр тогтоол гарч, хориглосон бүсээс зөвшөөрөгдсөн бүс рүү мал нүүлгэн шилжүүлэх тухай “Монгол мал” дэд хөтөлбөрийг баталсан бөгөөд 2017 онд Нийслэлийн Засаг даргын 592 дугаар захирамжийн дагуу хотын хориглосон бүс, нутагт байгаа малыг зөвшөөрсөн бүс нутаг руу шилжүүлэх ажил хийгдэж эхэлсэн. Чингэлтэй дүүрэг нь мал хориглосон бүсэд багтсан.

Дүүргийн хэмжээнд 2017 онд 1248 толгой мал тоологдсон, харин 2018 онд малтай өрхийг нүүлгэн шилжүүлэх ажил бүрэн хийгдсэн учир 2019 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор мал тооллогод хамрагдаагүй, дүүргийн нутаг дэвсгэрт байгаа тэжээвэр амьтанг тоолсон.

Зураг 2. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН МАЛЫН ТОО, толгойгоор 2002-2017 он






ТЭЖЭЭВЭР АМЬТАД:

Мал, Тэжээвэр амьтдын 2019 оны тооллогоор нийт 375 тэжээвэр амьтад тоологдсон нь өнгөрсөн оноос 27.7 хувиар буурсан байна. Тооллогоор 3 нугас, 9 цацагт хяруул, 147 тагтаа, 159 тахиа, 20 галуу, 31 туулай, 1 сүвдан гургуул, 5 бөднө тоологдсон байна.


Зураг 3. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, 2019 он



Хүснэгт 2. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, 2015-2019 он

Он	Бүгд	Гахай	Туулай	Илжиг	Шувуу
2015	815	0	29	2	784
2016	763	10	22	2	729
2017	578	6	19	2	551
2018	519	0	32	0	487
2019	375	0	31	0	344
Өсөлт, бууралт 2018/2019 хувиар	-27.7	-100	-3.1	-100	-29.4







ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР НОХОЙ, МУУР:

Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2002 оны 222 дүгээр тогтоолын 2 дахь хэсэг, 2015 оны 134 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2015 оны 870 дугаар захирамжийн дагуу мал тооллоготой хамтран гэрийн тэжээвэр нохой, муурны шинэчилсэн бүртгэл хийгдсэн бөгөөд 2019 онд 8279 нохой, 151 муур бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 187 (2.3%) нохойгоор, 26 (20.8 %) мүүраар нэмэгджээ.


Зураг 4. БҮРТГЭГДСЭН НОХОЙ, МУУРНЫ ТОО, 2015-2019 он



Зураг 5. БҮРТГЭГДСЭН НОХОЙ, МУУРНЫ ТОО, хороодоор, 2019 он



СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?



 **Цахимаар:**


www.1212.mn
www.ubstat.mn
www.chingeltei.gov.mn

 **www.nso.mn**

Та статистикийн мэдээллийг байнга авч байгааг хүсвэл ЭНД ДАРЖ бүртгүүлнэ үү

Энэ хэсэгт өөрийн e-mail хаягаа бүртгүүлснээр статистикийн мэдээллийг цаг алдалгүй тогтмол авч байх болно.

SOCIAL NETWORK

 www.facebook.com/StatisticChinaeltei

 www.twitter.com/statistic_mn

 Ухаанаг гар утас, таблет ашиглан статистик мэдээлэл авах ezStat аппликейшн

 Статистикийн хэвлэмэл бүтээгдэхүүнийг унших Монстат аппликейшн



 **Утсаар:**



70130767
11-310767
1900-1212

